

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТЭД 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО:

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Барилга, хот байгуулалтын яамны хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулан яам, холбогдох дээд байгууллагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТҮВШИНГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ:

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дүгээр тогтоолоор баталсан 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 34 зорилт, 70 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн түвшинг 2021 оны жилийн эцсийн байдлаар **91.3** хувьтай гэж үнэлэв. Үүнд: 100 хувьтай хэрэгжсэн 53, 90 хувьтай хэрэгжсэн 4, 70 хувьтай хэрэгжсэн 6, 50 хувьтай хэрэгжсэн 5, 30 хувьтай хэрэгжсэн 2 заалт бүхий ажлууд байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг харуулбал:

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Нийт арга хэмжээний тоо	Үүнээс						Хэрэгжилтийн түвшингийн дундаж үнэлгээ /%/
			100 %	90%	70%	50%	30%	0%	
1	ЗГҮАХХАХТ-ийн арга хэмжээ	70	53	4	6	5	2		91.3

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:

Хүснэгт-1.1

№	Бодлого											
	2	Гүйцэтгэл хувь	3	Гүйцэтгэл хувь	3	Гүйцэтгэл хувь	4	Гүйцэтгэл хувь	5	Гүйцэтгэл хувь	6	Гүйцэтгэл хувь
Хүний Хүний хөржлийн бодлого	Эдийн засгийн бодлого		Эдийн засгийн бодлого		Засаглалын бодлого		Ногоон хөржлийн бодлого		Нийслэл ба бүс, орон нутгийн хөржлийн бодлого			

1	2.1.3.11	100	3.5.7.1	100	3.7.7.2	100	4.2.5.3	100	5.1.1.4	100	6.1.9.2	100
2	2.1.12.6	100	3.5.7.2	100	3.7.7.3	100	4.2.7.6	100	5.1.4.1	100	6.1.10.1	100
3	2.1.14.2	100	3.7.1.1	70	3.7.8.1	100	4.2.10.2	100	5.1.4.2	100	6.1.10.2	100
4	2.2.3.8	100	3.7.1.2	70	3.7.9.1	70			5.1.9.1	100	6.1.10.3	100
5	2.3.9.7	100	3.7.1.3	50	3.7.9.2	100			5.1.12.2	100	6.2.2.2	100
6	2.6.1.7	90	3.7.1.4	100	3.7.9.3	50			5.1.12.6	100	6.2.2.3	100
7	2.6.1.11	100	3.7.1.5	50	3.7.9.4	100			5.1.12.7	100	6.2.7.1	100
8	2.6.3.2	90	3.7.1.6	100	3.7.9.5	50					6.2.7.2	100
9			3.7.2.3	30	3.7.9.6	100					6.2.9.1	100
10			3.7.2.5	100	3.7.9.7	100					6.2.11.1	70
11			3.7.2.6	100	3.7.9.9	100						
12			3.7.3.4	100	3.7.10.1	100						
13			3.7.3.5	30	3.7.11.3	100						
14			3.7.3.7	70	3.7.11.4	100						
15			3.7.3.8	70	3.7.11.5	100						
16			3.7.4.1	100	3.7.11.6	100						
17			3.7.4.3	100	3.7.12.3	90						
18			3.7.4.4	100	3.7.12.4	100						
19			3.7.5.1	100	3.7.13.1	90						
20			3.7.6.2	100	3.7.13.2	100						
21			3.7.7.1	50	3.7.13.3	100						

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна:

3.7.1.1. Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барина.

3.7.10.1. Бага, дунд орлоготой иргэдийг жилийн 4-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлж, зээл олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна.

3.7.11.4. "Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, цэвэр ус дамжуулах шугам, дагалдах тоног төхөөрөмж, ус цэвэршүүлэх станцыг барьж ашиглалтад оруулна.

3.5.7.1. Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ.

6.2.7.2. Сумын хөгжил арга хэмжээг хэрэгжүүлж, инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.

2.1.3.11, 2.1.12.6, 2.1.14.2, 2.2.3.8, 2.3.9.7. Захиалгын дагуу Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, боловсролын байгууллагуудын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ариун цэврийн байгууламжийг сайжруулах, барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.

3.7.4.3. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7.4.7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн, зураг төслийг боловсруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.7.9.7. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30 000 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7.11.6. Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.

Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай, 50 хувиас доош биелэлттэй дараах 7 ажил байна. Үүнд:

3.7.1.3. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барина.

3.7.1.5. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна.

3.7.2.3. Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна.

3.7.3.5. Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно.

3.7.7.1. "Шинэ Зуунмод", "Майдар" хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох судалгаа хийж, шийдвэрлүүлнэ.

3.7.9.3. "Баянголын амны орон сууц" барих төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

/3.7.9.5/ Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ:

1. "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т Барилга, хот байгуулалтын яамны хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үнэлгээ 91.3 хувьтай тодорхой үр дүнд хүрсэн байна.

2. Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж /Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын зураглал ба газрын кадастрын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл/ Засгийн газраар хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна.

3. Улсын хэмжээнд нийт 13 нэр төрлийн, 22 нэг маягийн давтан хэрэглэх зураг төслийг газар хөдлөлтийн 6-9 баллын бүсчлэлд нийцүүлэн боловсруулж холбогдох яамдуудад хүргүүлж ажилласан нь цаашид улсын төсвийг хэмнэх томоохон ажил болсон байна.

4. Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын ажлын ТЭЗҮ, зураг төсөл, судлагааны ажлуудыг эхлүүлсэн байна.

5. Бага дунд орлоготой иргэдийг жилийн 4-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд хамруулах арга хэмжээний хүрээнд Ипотекийн зээлийн хүүг 6 хувь болгож, санхүүжилтийг нэмэгдүүлэн ажилласан. Жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудад нийт 1.012.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 13,292 зээлдэгчидэд олгож 2020 онтой харьцуулахад даруй 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

6. "Тайшир-Алтай" төслийн хүрээнд цэвэр ус дамжуулах шугам, дагалдах тоног төхөөрөмж, ус цэвэршүүлэх станцыг амжилттай дуусган, ашиглалтад оруулснаар Алтай хотын хүн амыг баталгаат ундны усаар хангаж, Монгол улсын хэмжээнд анх удаа гадаргын усыг унд, ахуйн хэрэглээнд ашиглах жишиг төсөл болж чадсан байна.

7. Газар, хот байгуулалт, барилгын салбарын бүх төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрхтэй холбоотой үйл ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлж, цаг хугацаа, орон зайгаас үл хамаарсан иргэн төвтэй төрийн үйлчилгээг нэг цонхноос авах боломжийг бүрдүүлж, шат дамжлага, хүнд суртал, авилгын индекс бууруулах боломжийг бүрдүүлсэн байна.

8. 2021 оны Төсвийн тухай хуульд Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан 97 арга хэмжээ, Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах-145, нийт 242 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнгээр гэрээ байгуулахаас 2021 оны жилийн эцсийн байдлаар **228** төсөл, арга хэмжээний 187,3 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

9. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд аймаг сумын цэвэрлэх байгууламжийг сайжруулах ажлыг 11 аймагт эхлүүлж, 7 аймгийн цэвэрлэх байгууламж, ашиглалтанд орж, 4 аймгийн ажил 85 хувтай явагдаж байна. Мөн үлдсэн 8 аймгийн цэвэрлэх байгууламжийг барих ажлын гүйцэтгэгчийг шалгаруулан бэлтгэл ажлыг хангасан байна.

10. Сумын хөгжил арга хэмжээний хүрээнд 3 аймгийн 5 сумын инженерийн нэгдсэн шугам сүлжээг байгуулах ажлыг эхлүүлэн, амжилттай хэрэгжүүлж байна.

11. Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хууль, тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг хуулиуд нь Газрын багц хуулийн хэлэлцүүлгээс шалтгаалан хуулиудын нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээ удааширалтай байна.

12. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулах, байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулах, газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүр улсын төсөвт тусгах санал хүргүүлдэг боловч шийдэгдэхгүй байсаар байна.

13. "Шинэ Зуунмод", "Майдар" хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох судалгаа хийх арга хэмжээний хөрөнгө санхүүжилт мөн шийдэгдээгүйгээс шалтгаалан арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байдалт хүрч байна. Иймд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээрх зайлшгүй хэрэгжүүлэх, томоохон төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай байна.

ТАВ: САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Газрын багц хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хууль, Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулга, шинэчлэн боловсруулж дуусган яаралтай УИХ-д өргөн барьж батлуулахад холбогдох газрууд анхаарч ажиллах.

2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, БХБ-ын салбарт жендерийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тодорхой арга хэмжээг 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;

3. Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд арга хэмжээ тусган, хэрэгжүүлэн ажиллах;

4. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулах, байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулах, газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулахад 9 аймгийн мужлалын зураг боловсруулах ажлуудын санхүүжилтийг СЯ

болон холбогдох бусад эх үүсвэрээс шийдвэрлүүлэхэд СХОГ, бусад газрууд анхаарах

5. Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын даган хэрэгжиж байгаа хаяа хот, суурин газруудын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөөнд анхаарч болосруулан, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэн хэрэгжүүлэхэд онцгой анхаарах

6. "Шинэ Зуунмод", "Майдар" хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох судалгаа хийх арга хэмжээний хөрөнгө санхүүжилт мөн шийдэгдээгүйгээс шалтгаалан арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байдалт хүрч байна. Иймд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээрх зайлшгүй хэрэгжүүлэх, томоохон төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай байна.

7. Төв, орон нутгийн орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг нарийн мэргэжлийн Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч холбогдох арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;

8. Чиг үүргийн яамдтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт, хийгдэх ажил тодорхойгүй байгаа зэрэг асуудлуудыг цэгцэлж, нэг мөр болгох, төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтэнд анхаарах

9. Инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн чиглэлийн ажлуудын хэрэгжүүлэх арга хэмжээг дагуул хаяа шинэ хотууд байгуулахтай холбоотой ерөнхий төлөвлөгөө болон шинээр баригдаж байгаа төсөл арга хэмжээнүүдтэй уядлуулан газрын төлөвлөгөөндөө нарийвчлан тусгаж, тодорхой болгож санхүүжилтийг шийдвэрлүүлэх;

10. Үйл ажиллагааны хөтөлбөрт туссан нийслэлийн хариуцан хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх, хамтран ажиллах уялдаа холбоог сайжруулан ажиллах

11. Дэлхий нийтэд тархсан цар тахал КОВИД-19-ын вирусын халдвар гарсантай холбоотой давагдашгүй хүчин зүйл нөлөөллийг тооцож төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарах;

12. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай, хэрэгжилт хангалтгүй 7 арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажиллахыг ТНБД, харъяа газрууд, яамны холбогдох газар, хэлтсийн дарга нарт тус тус зөвлөж байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

